

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙГООР  
ХУУЛЬ ХООРОНДЫН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ЗОРИЛГООР  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН БУСАД ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 12 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 06 дугаар сарын 09, 15-ны өдрүүдэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, хэлэлцүүлгийн явцад хуралдаан даргалагчаас дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороонд тус тус шилжүүлсэн билээ.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хороо төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж, анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Инновац, цахим бодлогын байнгын хороонд ирүүлсэн.

Байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хуулийн төслийдийг хэлэлцүүлэгт бэлтгэх явцад Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийд “бичгээр” гэсний дараа “эсхүл цахим хэлбэрээр” гэж нийтлэг байдлаар тусгахаар оруулж байгаа өөрчлөлт нь тухайн хуулиар зохицуулсан харилцаанаас хэт өргөн агуулгаар тусгасан нь цаашид хууль хэрэглээний явцад тодорхойгүй нөхцөл байдал бий болох тул төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдтэй, хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагатай, иргэн хоорондын харилцааг тус бүрээр нь ангилж холбогдох өөрчлөлтийг тусгалаа.

Тухайлбал, төрийн байгууллага, албан тушаалтан хоорондоо цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн, тус хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем болон албаны цахим шууданг ашиглахаар;

-Хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллага албан тушаалтантай харилцах харилцаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан системүүд болон эрх зүйн үр дагавраас хамаарч Иргэний хууль болон Цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг, тоон гарын үсгийг тус тус хэрэглэхээр;

-Мөн эрх зүйн үр дагавар багатай, эсхүл тухайн салбарын хууль тогтоомжоор баталгааждаг болон хуульд амаар гүйцэтгэж болохоор тусгасан харилцаанд аливаа хэлбэр заахгүй байх зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан.

Ажлын хэсгийн хуралдаанаар дэмжсэн 43 хуулийн төслийн 52 зарчмын зөрүүтэй саналын томьёолол, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар гаргасан хоёр зарчмын зөрүүтэй саналын томьёолол, найруулгын нэг санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дэмжсэн нийт 28 хуулийн төслийн 36 зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “Цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй адил хүчинтэй байх бөгөөд зөрсөн тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол анх баталгаажсан баримт бичгийн хэлбэр (цаашид “баримт бичгийн эх хувь” гэх)-ийг баримтална.” гэж заасны “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй.

Байнгын хорооны хуралдаанаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон хуулийн төслийдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

